-аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
-Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч
-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны нөөц, ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын химийн бодис, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн
-Боловсрол, соёл урлагийн газрын төсвийн мэргэжилтэн
-Боловсрол, соёл урлагийн газрын эрүүл мэндийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
-Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга
-Усны сав газрын гадаргын усны нөөц судалгаа шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
-Усны сав газрын газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
-Ундарга-Алтай" ОНӨҮГ-ын усны инженер
-Ундарга-Алтай" ОНӨҮГ-ын худаг хариуцсан мэргэжилтэн
-Есөнбулаг сумын эрүүл ахуй, тохижилт үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
-Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар
-Сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нар

__o0o__

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн А/575 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

УС, ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН АЙМГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	-аймгийн Засаг даргын орлогч
Зөвлөлийн дэд дарга:	-НҮБ-ын Хүүхдийн Сангийн Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үндэсний зөвлөх
Зөвлөлийн нарийн бичгийн дарга:	-Эрүүл мэндийн газрын дарга
Зөвлөлийн гишүүд:	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга -Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга -Мэргэжлийн хяналтын газрын дарга -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга -Боловсрол, соёл урлагийн газрын дарга -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга -Есөнбулаг сумын Засаг дарга -Сумын Тамгын газрын дарга нар -Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга -“Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргаа”-ны дарга -“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын дарга -Алтай хотын Тохижилт үйлчилгээний газрын дарга

__o0o__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/576 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 114 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт хийгдэх ГААОНӨГ/201907051 дугаартай ЛЕД дэлгэц суурилуулах, тохижуулах ажлыг Ш.Соронзонболд ахлагчтай иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021879

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/577 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн ГААОНӨГ/201907050 дугаар гэрээтэй Алтай хотын 70 жилийн цэцэрлэгт хүрээлэнгийн цэцэрлэгт хүрээлэн тохижилтын ажлыг гүйцэтгэж дуусан тул тус ажлыг хүлээн авч, байнгын ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Д.Батмагнай -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Н.Энхбаяр -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Н.Энхтуяа -Есөнбулаг сумын Барилга, хөрөнгө оруулалт, СӨХ хариуцсан мэргэжилтэн

Б.Эрдэнэбаяр -Сум дундын Ойн ангийн дарга

Н.Саранболд -Хот тохижилтын газрын дарга

З.Мөнхнасан -Өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

О.Бат-Эрдэнэ -Иргэдийн бүлгийн ахлагч

2.Алтай хотын 70 жилийн цэцэрлэгт хүрээлэнгийн цэцэрлэгт хүрээлэн тохижилтын ажлыг гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, барааны тоо хэмжээтэй нийцүүлэн хянаж авах, холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Д.Батмагнай)-т үүрэг болгосугай.

3.Хүлээн авсан хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авч хөрөнгийн хөдлөлт, өөрчлөлтийг хийж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Сум дундын Ойн анги (Б.Эрдэнэбаяр)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHIR-3A-4.doc

021855

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/678 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн ГААОНӨГ/201907052 дугаар гэрээтэй Дашпэлжээлин хийдийн тохижилтын ажлыг гүйцэтгэж дууссан тул тус ажлыг хүлээн авч, байнгын ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Алтайбаатар -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Б.Балдорж -Орон Өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Н.Жаргалсайхан -Боловсрол соёл, урлагийн газрын Соёл, урлаг, дуу хөгжмийн боловсрол хариуцсан мэргэжилтэн

М.Мөнхцэцэг -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн

Б.Алтаншагай -Иргэдийн бүлгийн ахлагч

2.Дашпэлжээлин хийдийн тохижилтын ажил гүйцэтгэлийг гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, барааны тоо хэмжээтэй нийцүүлэн хянаж авах, холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Б.Алтайбаатар)-т үүрэг болгосугай.

3.Хүлээн авсан хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авч хөрөнгийн хөдлөлт, өөрчлөлтийг хийж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Дашпэлжээлин хийдийн хамба лам (Б.Ууганбаяр)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021869

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/579 Алтай хот

Салбар хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 323 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар аймгийн хэмжээнд зөвлөлдөж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий аймгийн Салбар хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Жендэрийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад тус тус үүрэг болгосугай.

3.Жендэрийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, зохион байгуулсан ажлын тайлангаа аймгийн Салбар хороонд хагас, бүтэн жилээр тайлагнаж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/37 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021851

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 08 өдрийн А/579 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: -аймгийн Засаг дарга

Дэд дарга: -аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:
-Засаг даргын Тамгын газрын дарга
-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
-Эрүүл мэндийн газрын дарга
-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
-Статистикийн хэлтсийн дарга
-Цагдаагийн газрын дарга
-Иргэний нийгмийн байгууллагуудын нэгдсэн зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)
-Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)
-Залуучуудын холбооны дарга (зөвшилцсөнөөр)
-Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь ажилтан (зөвшилцсөнөөр)

__o0o__

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 08 өдрийн А/579 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН САЛБАР ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрэм нь аймгийн жендэрийн салбар хороо (цаашид "салбар хороо" гэх)-ны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Салбар хорооны үндсэн зорилго нь жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хэрэгжиж буй бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад оршино.

1.3 Салбар хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, бусад хууль тогтоомж, жендэрийн үндэсний хорооны дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Салбар хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1 Салбар хороо нь төр, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангасан төлөөллөөс бүрдсэн байна.

2.2 Шаардлагатай бол салбар хороо жендэрийн эрх тэгш байдлыг хангах тодорхой асуудлаар зөвлөл, ажлын хэсэг, шинжээчдийн бүлэг байгуулан ажиллуулж болно.

2.3 Салбар хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь салбар хорооны хуралдаан байна.

2.4 Салбар хорооны хуралдааныг улиралд нэг удаа зохион байгуулна. Шаардлагатай бол Салбар хорооны даргын санаачилгаар, эсхүл гишүүдийн олонхийн саналаар тухай бүр хуралдуулж болно.

2.5 Салбар хорооны нийт гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.6 Салбар хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.7 Салбар хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлыг хуралдааны тэмдэглэл хөтөлж баталгаажуулах бөгөөд салбар хорооны дарга хянаж гарын үсэг зурна.

Гурав. Салбар хорооны чиг үүрэг

3. Салбар хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр аймгийн дэд хөтөлбөр боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

3.2 Тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн

төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

3.3 Тухайн салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан болон жендэрийн статистикийн мэдээллийг бүрдүүлэх, дүгнэлт гаргах;

3.4 Төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүрэг болон судалгаа, дүн шинжилгээний ажлыг олон нийт, төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах;

3.5 Тухайн салбар, орон нутгийн хэмжээнд жендэрийн сургалт, сурталчилгаа, гэгээрлийн ажил зохион байгуулах, бусад аймгуудад туршлага судлах;

3.6 Ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх чиглэлийн арга хэмжээг тухайн салбар, орон нутгийн онцлог, шаардлагад нийцүүлэн зохион байгуулах;

3.7 Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, хамгаалах байртай болж, нэгдсэн эмнэлгийн дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, залуу гэр бүлийн зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж хэвших;

3.8 Тухайн салбарыг хариуцдаг байгууллага болон сумдаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүн, судалгаа шинжилгээний тайланг авч нэгтгэн, хэлэлцүүлж, Жендэрийн үндэсний хороонд хуульд заасан хугацаанд хүргүүлэх;

Дөрөв. Салбар хорооны дарга, гишүүний бүрэн эрх

4.1 Салбар хорооны дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.1.1 Салбар хорооны бүрэлдэхүүнийг санал болгох;

4.1.2 Салбар хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

4.1.3 Салбар хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

4.1.4 Салбар хорооны гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих;

4.1.5 Салбар хорооны үйл ажиллагааны тайланг гишүүдээр хэлэлцүүлэх;

4.2 Салбар хорооны гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.2.1 Салбар хорооны хуралдаанд асуудал оруулж хэлэлцүүлэх;

4.2.2 Салбар хорооны шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хариуцсан салбар, чиглэлийн дагуу хяналт тавих;

4.2.3 Салбар хорооны даргын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах;

4.2.4 Хариуцсан салбар, чиглэлийн дагуу салбар хороонд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримтыг гаргаж өгөх;

4.2.5 Салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах, салбар хорооноос хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах;

4.3 Салбар хорооны даргын түр эзгүйд түүний үүрэг болгосноор бүрэн эрхийг нь нийгмийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч хэрэгжүүлнэ.

4.4 Салбар хорооны нарийн бичгийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.4.1 Салбар хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, салбар хорооны даргаар батлуулах;

4.4.2 Салбар хорооны хуралдааны тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.4.3 Тайлан, судалгааг нэгтгэж салбар хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

Тав. Салбар хороо

5.1 Салбар хороог аймгийн Засаг дарга ахалж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засаг даргын захирамжаар батална.

5.2 Салбар хороо нь эрхэлсэн салбарын хэмжээнд болон харьяа нутаг дэвсгэртээ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр, Үндэсний хорооноос гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

5.3 Салбар хороо нь тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулна.

5.4 Салбар хорооны үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон бусад зохион байгуулалтын зардлыг орон нутгийн төсөвт тусгуулж санхүжүүлнэ.

5.5 Салбар хорооны нарийн бичгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэсэн төрийн албан хаагчид Жендэрийн үндэсний хорооны тогтоолын дагуу үндсэн цалингийн 30 хувийн нэмэгдэл олгоно.

5.6 Салбар хороо нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд ажлаа тайлагнана.

5.7 Салбар хороо нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19.1.8, 19.1.9-д заасан тайланг бэлтгэх ажлыг хариуцан зохион байгуулна.

Зургаа. Салбар хорооны үйл ажиллагааны зардлын санхүүжилт

6.1 Салбар хорооны үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

Долоо. Сумдын ажлын хэсэг

7.1 Сумдад жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг хүн амын асуудал хариуцсан ажлын хэсэг хариуцаж ажиллана.

7.2 Ажлын хэсэг тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулна.

7.3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.

7.4 Тухайн салбар, сум орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

7.5 Тухайн салбар, сумын хэмжээнд хүйсээр ангилсан болон жендэрийн статистикийн мэдээллийг бүрдүүлэх, дүгнэлт гаргах;

7.6 Хүн амын хөгжил, жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүрэг болон судалгаа, дүн шинжилгээний ажлыг олон нийт, төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах;

7.7 Тухайн салбар, сумын хэмжээнд жендэрийн сургалт, сурталчилгаа, гэгээрлийн ажил зохион байгуулах;

7.8 Ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх чиглэлийн арга хэмжээг зохион байгуулах;

7.9 Сумдад хамгааллын багийг байгуулж, бүтэц, чиг үүргийг тодорхойлж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг хамгааллын байртай хамтатган ажиллуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, залуу гэр бүлийн зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж хэвших;

7.10 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүн, судалгаа шинжилгээ, үндэсний хөтөлбөрүүдийн тайланг нэгтгэн, ажлын хэсгээр хэлэлцүүлж, аймгийн жендэрийн салбар хороо, холбогдох агентлагуудад жил бүрийн 06, 12 сарын 25-ны дотор хүргүүлэх;

__o0o__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/580 Алтай хот

Газар эзэмших эрх хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.1 дахь заалт, 40.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчимд нийцээгүй хууль зөрчин гарсан 3 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2.Дээрх нэр бүхий нэгж талбарт газар эзэмших эрх нь хүчингүй болсон 3 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 10 хоногийн дотор албан ёсны эрх нь цуцлагдсан мэдэгдлийг хүргүүлж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/338, А/396 дугаар захирамж, 2019 оны А/235 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc
021883

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 08 өдрийн А/580 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ БАЙГАА ГАЗРЫН ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Эзэмшигчийн нэр	Зориулалт	Газрын хэмж /м2/	Газрын байршил
1	"Өөдрөг баян" ХХК	Худалдааны төв	18000.0	Баянхайрхан баг Солонго хороолол
2	"Монцулхир" ХХК	Орон сууц	678.5	Баянхайрхан баг Солонго хороолол
3	Ш.Шинэбаяр	Орон сууц	678.5	Баянхайрхан баг Солонго хороолол

__oOo__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/581 Алтай хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий бусад газар эзэмших хүсэлт гаргасан иргэн Батсүхийн Бөхбаатарын эзэмших газрын зориулалт, хэмжээ, байршлыг 1-2 дугаар хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн Б.Бөхбаатарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 154 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021885

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 08 өдрийн А/581 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Эзэмшигчийн нэр	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Хугацаа /жил/	Газрын байршил
1	Б.Бөхбаатар	Үйлчилгээ	220	6	Жаргалант баг

__oOo__

ИРГЭН Батсүх ОВОГТОЙ Бөхбаатар (ДЮ75031772) - ИЙН
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг



Аймгийн Засаг даргын
20 19 оны 11 дугаар сарын 07 -ны өдрийн
A/581 дугаар захирамжийн 2 -р хавсралт

Огноо: 2019-10-23

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5139776.692	287655.823	14.68	1-2
2	5139790.573	287660.596	14.97	2-3
3	5139785.674	287674.736	14.30	3-4
4	5139772.004	287670.557	15.46	4-1

Талбайн хэмжээ: 220.0 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 19 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/582 Алтай хот

Газар зүйн нэрийн салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1, 5.8.2, 5.8.4, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны "Нутаг орны газар зүйн нэрийн хамгаалах тухай" 186 дугаар зарлиг, Улсын Их Хурлын 2003 оны "Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай" 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн "Газар зүйн нэрийн салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:	Ж.Ганбат	-аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Б.Бямбадорж	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	А.Амарзаяа	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
	П.Баасан	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Ч.Жаргалсайхан	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	М.Мандахжүү	-Архивын тасгийн дарга
	М.Мөнхболд	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Удирдлагын хэлтсийн дарга
	Д.Төмөрбаатар	-Цэргийн штабын дарга
	Д.Болдсайхан	-Цагдаагийн газрын дарга
	Р.Батмөнх	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
	Б.Баян-Эрдэнэ	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Д.Батмагнай	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Л.Ганхуяг	-Орон нутгийн өмчийн газрын дарга
	Б.Жаргалсайхан	-"Мэдээлэл, холбоо сүлжээ" ТӨХК-ий захирал
	А.Пүрэвсүрэн	-"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн захирал

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021881

Г.Болд-Эрдэнэ -Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын геодези,
зураг зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн

2.“Газар зүйн нэрийн салбар зөвлөл” байгуулахтай холбогдуулан 18 суманд зөвлөл байгуулах тухай заавар, зөвлөмжийг хүргүүлж, хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллахыг ажлын хэсэг (Салбар зөвлөлийн дарга)-т даалгасугай.

3.“Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг аймгийн хэмжээнд хийх” ажлыг зохион байгуулах, “Газар зүйн нэрийн мэдээллийн сан” бүрдүүлэх, шинээр өгөх, өөрчлөх газар зүйн нэрийн саналыг хэлэлцэн Газар зүйн нэрийн зөвлөлд хүргүүлэх болон бусад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухай бүрд шийдвэрлэн ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр Дугаар А/583 Алтай хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/459 дугаартай гамшгийг сангийн хөрөнгөөр малчдад захиалгын дагуу 160 тонн өвс нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулах тухай захирамжийн 1 дэх заалтын Төрийн бус байгууллагын төлөөллийн гишүүн Б.Оюунчимэг гэснийг Г.Ундрам болгон өөрчилсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Л.Батбаатар)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021902

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр Дугаар А/584 Алтай хот

"Солонго" хорооллын 120 айлын орон сууцны барилгыг орон нутгийн өмчид хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захираа, нутаг дэвсгэйн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 84 дүгээр тогтоол, Хөгжлийн банкны 2019 оны 4/1404 дүгээр албан бичиг, Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Есөнбулаг сумд баригдсан "Солонго" хорооллын 120 айлын орон сууцны барилгыг орон нутгийн өмчид хүлээн авахтай холбогдуулан ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Солонго" хорооллын 120 айлын орон сууцны барилгыг орон нутгийн өмчид хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Ганбат	-аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Л.Ганхуяг	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Гишүүд:	Ч.Жаргалсайхан	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	П.Баасан	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,төлөвлөлтийн хэлтсийн дарга
	М.Амгалан	-Есөнбулаг сумын Засаг даргын орлогч
	Б.Бямбадорж	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Б.Дэлгэр	-"Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын захирал
	Б.Түмэнбаатар	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Б.Бээжин	-"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий инженер
	С.Булгантамир	-"Ундарга-Алтай"ОНӨААТҮГ-ын дарга

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021905

2.

Л.Очир -"Солонго дулааны станц" ОНӨААТҮГ-ын захирал

Н.Саранболд -Алтай хотын Тохижилт, үйлчилгээний газрын дарга

Д.Цэвэлмаа -"Монголын цахилгаан холбоо сүлжээ" ТӨХХК-ийн ерөнхий инженер

2.Орон сууц, гадна тохижилтын бүрэн байдлыг хангуулж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Ганбат)-д үүрэг болгосугай.

3.Орон сууц ашиглалтад орж байгаатай холбогдуулан түрээсийн орон сууцыг борлуулах, түрээсээр өмчлүүлэх, орон сууцны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг "Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын захирал (Б.Дэлгэр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 12 өдөр Дугаар А/585 Алтай хот

Бүтэц орон тоо шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.8 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 81 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/205 дугаар захирамжаар батлагдсан Сум дундын ойн ангийн орон тоог 24, Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын орон тоог 43 болгож шинэчлэн баталсугай.

2.Сум дундын ойн ангийн бүтцийг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Батлагдсан орон тоо болон цалингийн санд багтаан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4.Бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан Сум дундын ойн анги, Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын төсвийг шинэчлэн баталж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4.doc
021893

Аймгийн Засаг даргын 2019 оны
дугаар сарын ... -ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН БҮТЭЦ

__oOo__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 12 өдөр Дугаар А/586 Алтай хот

Дарив сумын Хужирт багийн төвийн
барилгын ажилд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 07 сарын 17-ны өдрийн 07 дугаартай тогтоолоор батлагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Дарив сумын Хужирт багийн төвийн барилгын ажилд 7500000 (долоон сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Дарив сумын Засаг дарга (М.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021830

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 12 өдөр Дугаар А/587 Алтай хот

Газар эзэмших эрх хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий газарт газар эзэмших хүсэлт гаргасан "Авто тээврийн үндэсний төв" ТӨААТҮГ-ын Говь-Алтай аймаг дахь салбарын эзэмших газрын зориулалт, хэмжээ, байршлыг 1-5 дугаар хавсралтаар баталж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн "Авто тээврийн үндэсний төв" ТӨААТҮГ-ын Говь-Алтай аймаг дахь салбарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4.doc

021899

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 12 өдрийн А/587 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Эзэмшигчийн нэр	Зориулалт	Газрын Хэмжээ /м2/	Хугацаа /жил/	Газрын байршил
1	Аймгийн Авто тээврийн төв	Төрийн үйлчилгээ (зогсоол)	853.0	15	Жаргалант баг, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн хойд талд
2	Аймгийн Авто тээврийн төв	Төрийн Үйлчилгээ (Авто вокзал)	7402.0	15	Жаргалант баг Хуучин нисэх

__ оОо __

"Аймгийн Авто тээврийн төв" ТӨААТҮГ (5324165) - ИЙН ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг

Аймгийн Засаг даргын
2019 оны 11 дугаар сарын 12 -ны өдрийн
A/587 дугаар захирамжийн 2 -р хавсралт



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Огноо: 2019-11-11

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5139635.668	287683.429	9.87	1-2
2	5139643.390	287677.277	10.68	2-3
3	5139648.831	287668.087	6.37	3-4
4	5139654.177	287664.615	10.89	4-5
5	5139664.474	287661.087	3.33	5-6
6	5139667.455	287662.579	21.63	6-7
7	5139674.512	287683.027	24.53	7-8
8	5139657.318	287700.518	27.58	8-1

Талбайн хэмжээ: 853.0 квадрат метр

"Аймгийн Авто тээврийн төв" ТӨААТҮГ (5324165) - ИЙН ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг

Аймгийн Засаг даргын
2019 оны 11 дугаар сарын 13 -ны өдрийн
A/587 ... дугаар захирамжийн 3 -р хавсралт

Огноо: 2019-11-11



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5139635.668	287683.429	9.87	1-2
2	5139643.390	287677.277	10.68	2-3
3	5139648.831	287668.087	6.37	3-4
4	5139654.177	287664.615	10.89	4-5
5	5139664.474	287661.087	3.33	5-6
6	5139667.455	287662.579	21.63	6-7
7	5139674.512	287683.027	24.53	7-8
8	5139657.318	287700.518	27.58	8-1

Талбайн хэмжээ: 853.0 квадрат метр

"Аймгийн Авто тээврийн төв" ТӨААТҮГ (5324165) - ИЙН ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг

Аймгийн Засаг даргын
2019 оны 11 дугаар сарын 12 -ны өдрийн
A/587 дугаар захирамжийн 9 -р хавсралт

Огноо: 2019-11-11



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5139635.668	287683.429	9.87	1-2
2	5139643.390	287677.277	10.68	2-3
3	5139648.831	287668.087	6.37	3-4
4	5139654.177	287664.615	10.89	4-5
5	5139664.474	287661.087	3.33	5-6
6	5139667.455	287662.579	21.63	6-7
7	5139674.512	287683.027	24.53	7-8
8	5139657.318	287700.518	27.58	8-1

Талбайн хэмжээ: 853.0 квадрат метр